

## 3

## МОНГОЛЫН БАРУУН БУСИЙН ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

**С. Бурмаа**

### 1. Баруун бусийн жижиг дунд үйлдвэрлэлийн өнөөгийн байдал

Монгол орны Баруун бүс нь Монгол орны газар нутгийн 26.5 хувийг, хүн амын 16 орчим хувийг, нийт мал сүргийн 30 гаруй хувийг эзлэдэг томоохон бусийн нэг бөгөөд бусад бүсүүдийг бодвол харьцангуй алслагдмал байдгаараа онцлог юм.

Аливаа улс орон, бүс нутгийн хөгжлийг тодорхойлогч гол хүчин зүйл бол үйлдвэрлэл байdag. Иймээс Монгол улсын баруун бүс нутгийн хувьд үйлдвэрлэл бол гол салбарын нэг бөгөөд үйлдвэрлэлийн өнөөгийн төлөв байдлыг судлаж, цаашид хөгжүүлэх бодлого, чиглэлээ үндэс суурьтай тодорхойлох нь чухал юм.

Энэхүү судлагааг ARC олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр хийсэн бөгөөд судлагааны гол зорилго нь баруун бусийн жижиг дунд үйлдвэрлэлийн өнөөгийн байдлыг судлаж, хөгжүүлэхэд учирч болох саад бэрхшээл, сүл тал болон нөөц боломжийг тодорхойлоход чиглэж байгаа юм.

Баруун бүсийн жижиг дунд үйлдвэрлэлийн өнөөгийн байдлыг судлаж, хөгжүүлэхэд учирч болох саад бэрхшээл, сүл тал болон нөөц боломжийг тодорхойлоход чиглэж байгаа юм.

**Баруун бүсийн улсад бүртгэлтэй аж ахуй нэгжийн тоо, чиглэл**

Ямарваа нэгэн бизнесийг эрхлэн явуулахдаа аж ахуйн нэгж хэлбэрээр зохион байгуулбал илүү удирлага зохион байгуулалттайгаар үйл ажиллагаагаа явуулах боломж бүрддэг. Иймээс хамгийн түрүүнд баруун бүсийн улсад бүртгэлтэй аж ахуйн нэгжийн тоо, чиглэлийг судласан юм.

**Баруун бүсийн улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж байгууллагын тоог бусад бүсүүдтэй харьцуулсан байдал**

/2006 оны байдлаар /

№	Бүсийн нэр	Нийт тоо	Нийт дунд эзлэх хувь
1	Баруун бүс	3271	<b>6.6</b>
2	Хангайн бүс	4758	<b>9.7</b>
3	Төвийн бүс	6211	<b>12.7</b>
4	Зүүн бүс	1760	<b>3.6</b>
5	Улаанбаатар	32879	<b>67.2</b>
6	<b>Нийт</b>	<b>48879</b>	<b>100</b>

Эх үүсвэр: УСГ, Монгол улсын статистикийн эмхэтгэл 2006 он

2006 оны байдлаар улсад нийт 48849 аж ахуй нэгж байгаагаас баруун бүсэд 3271 буюу 6.6% нь оршиж байна. Энэ нь бусад бүсүүдтэй харьцуулахад 2-9 дахин бага аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулж байна гэдгийг харуулж байна.

**Баруун бүсийн улсад бүртгэлтэй аж ахуй нэгж байгууллагын тоо /аймгуудаар/**

№	Он	2003	2004	2005	2006
Аймгийн нэр					
1	Баян -Өлгий	521	568	596	642
2	Говь-Алтай	519	513	524	543
3	Завхан	542	572	620	682
4	Увс	628	569	570	620
5	Ховд	652	675	737	784
6	<b>Нийт</b>	<b>2862</b>	<b>2897</b>	<b>3047</b>	<b>3271</b>

Эх үүсвэр: УСГ, Монгол улсын статистикийн эмхэтгэл 2006 он

Баруун бүсийн улсад бүртгэлтэй аж ахуйн нэгжийн тоо жилээс жилд нэмэгдэх хандлагатай байгаа нь дээрх тоо баримтаас харагдаж байгаа бөгөөд

энэ нь баруун бүсийн бизнес эрхлэгчдийн тоо нэмэгдэж байгааг харуулж байгаа хэдий ч аж ахуй нэгж хэлбэрээр бүртгүүлчихээд үйл ажиллагаагаа идэвхтэй явуулдаггүй аж ахуй нэгжүүд байна.

Баруун бүсийн улсад бүртгэлтэй аж ахуй нэгжийн тооны нийт дунд эзлэх хувиар Ховд аймаг тэргүүлж байгаад бөгөөд бусад аймгуудын хувьд ойролцоо түвшинтэй байна. Энэ нь Ховд аймаг бусад аймгуудаа бодвол бизнес эрхлэгчдийн тоогоор илүү байна гэдгийг харуулж байгаа бөгөөд нөгөө талаар үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны хүрээ өргөн байна гэдэг нь харагдаж байна.

Баруун бүсийн улсад бүртгэлтэй бизнесийн байгууллагын чиглэлийг үндсэн 3 салбарыар авч үзвэл /давхардсан тоогоор/

Хэмжих нэгж	Үйлдвэрлэл	Үйлчилгээ	Худалдаа	Нийт дун
Тоо	1141	761	1490	3392
Хувь	33.6	22.4	43.9	100%

Өнөөдөр баруун бүсэд худалдааны чиглэлээр бизнес эрхлэгчид олон байгаа гэдэг нь тодорхой байгаа бөгөөд энэ нь техник, тоног төхөөрөмж, технологи шаардагдахгүй, эрсдэл харьцангуй багатай, үйлдвэрлэл явуулахад эрчим хүчний тогтвортой эх үүсвэр дутмаг зэрэг шалтгаантай холбоотой юм. Мөн нөгөө талаар баруун бүсийн хүн ам хэрэглээний дийлэнх хувийг өөрсдөө үйлдвэрлэхгүй бусдаас авч байна гэсэн үг юм.

**Баруун бүсийн жижиг дунд үйлдвэрлэлийн тоо, чиглэл, үйлдвэрлэлийн хэмжээ.**

Баруун бүс нь Монгол орны Дотоодын нийт бүтээгдэхүүний /2006 оны байдлаар/ 8.1 хувийг, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтын 0.6 хувийг, нийт ажиллагсадын 16.5 хувийг эзэлж байна. Баруун бүсэд ойролцоогоор 700 гаруй жижиг дунд үйлдвэрлэл үйл ажиллагаа явуулж байна. Жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлийн хувьд 20 гаруй гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа бөгөөд хүнсний үйлдвэрлэл голлох байр суурь

эзэлж байна. Доорх тоо баримтаас харахад хөдөө аж ахуйн гаралтай эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл бага байр суурь эзэлж буй нь хөдөө аж ахуйн түүхий эдийн нөөц арвантай бүс нутгийн хувьд харамсалтай санагдаж байна.

**Баруун бүсийн жижиг дунд үйлдвэрийн тоо /аймгуудаар /**

№	Хэмжих нэгж	Завхан	Ховд	Баян - Олгий	Увс	Говь - Алтай	Нийт дүн
1	Тоо	148	177	195	124	155	799
2	Нийт дүнд эзлэх %	11.8	22.1	24.4	15.5	19.3	100%

Эх үүсвэр : Баруун бүсийн эдийн засгийн орчны судлагаа 2006

**Баруун бүсийн жижиг дунд үйлдвэрийн тоо, чиглэл**

/2005 оны байдлаар/

№	Чиглэл	Завхан	Ховд	Баян-Олгий	Увс	Говь-Алтай	Нийт тоо	Нийт хувь
1	Мах боловсруулах үйлдвэр	2	5	9	7	2	25	3.1
2	Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэр	9	10	10	3	7	39	4.8
3	Архи, дарсны үйлдвэр	3	3	2	3	3	14	1.7
4	Талх, талхан бүтээгдэхүүн үйлдвэр	5	14	4	6	6	35	4.3
5	Арьс шир боловсруулах үйлдвэр	1	2	6	4	3	16	2
6	Барилга угсралт	16	32	35	12	19	114	14.2
7	Мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл	39	11	17	15	21	103	12.8
8	Нэхмэлийн үйлдвэр	1	4	9	5	3	22	2.7
9	Хүнс/ундааны үйлдвэр	36	61	59	42	36	234	29.2
10	Хувцас үйлдвэрлэл	2	4	5	4	6	21	2.6
11	Цахилгаан дулаан үйлдвэрлэл	11	3	4	3	14	35	4.3
12	Малын тэжээл үйлдвэрлэл	3	6	12	4	7	32	4

13	Гурил үйлдвэрлэл	6	4	3	6	8	27	3.3
14	Гутал үйлдвэрлэл	10	6	2	2	9	29	3.6
15	Жимс ногоо боловсруулах үйлдвэрлэл	3	5	2	2	4	21	2.6
16	Хивсний үйлдвэрлэл	1	-	-	-	-	1	0.1
17	Уул уурхай, олборлох үйлдвэр	7	16	6	7	36	4.5	
	<b>Нийт дүн</b>	<b>148</b>	<b>177</b>	<b>195</b>	<b>124</b>	<b>155</b>	<b>799</b>	<b>100%</b>

Эх үүсвэр : Баруун бүсийн эдийн засгийн орчны судлагаа 2006

Баруун бүсийн аймгууд төвөөс алслагдмал, зам харилцааны хөгжил бусад бүсүүдийг бодвол дутмаг хэдий ч тодорхой хэмжээгээр өөр өөрийн онцлогтой уялдуулж үйлдвэрлэл эрхэлж байна.

**Баруун бүсийн жижиг дунд үйлдвэрлэлийн өнөөгийн байдалд өгсөн дүгнэлт**

Баруун бүсийн жижиг дунд үйлдвэрлэлийн өнөөгийн байдлыг судлаж үзсний дунд дараах дүгнэлтүүд гарч байна. Үүнд:

- Баруун бүс нутагт үйлдвэрлэл бага зэргээр хөгжиж байгаа хэдий ч бүс нутгийн хөгжлийг тодорхойлох, бүс нутаг бие дааж хөгжих, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах түвшинд хүртэл хөгжиж чадахгүй байна.
- Томоохон хэмжээний үйлдвэрлэгчидийн тоо цөөн байгаа бөгөөд гол төлөв 1-9 ажиллагсад жижиг үйлдвэрүүд зонхилж байна.
- Баруун бүсийн хувьд үйлдвэрлэлийн олон чиглэл төрөл байгаа хэдий ч өнөөдөр үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний нэр төрлийн хувьд цөөн байна
- Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь өрсөлдөх чадварын хувьд хязгаарлагдмал. Учир нь дотоодын болон гадаад зах зээлд өрсөлдөж чадахуйц технологи, тоног төхөөрөмжөөр хангагдсан байдал бага, нарийн мэргэшсэн боловсон хүчний хүрэлцээ дутмаг, санхүүгийн өндөр хүчин чадал бага зэрэгтэй холбоотой

- Экспортын баримжаатай үйлдвэрийн тоо хангалтгүй байгаа бөгөөд мал аж ахуйн гаралтай анхан шатны боловсруулалт хийсэн бүтээгдэхүүн голлох байр суурь эзэлж байна
- Баруун бүсийн зарим үйлдвэрүүд хүчин чадлаараа бүрэн гүйцэд ажиллаж чадахгүй байна
- Баруун бүсэд жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломж, нөөц байгаа  
**Баруун бүсэд жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх давуу тал боломж**
- Монгол улсын нийт мал сүргийн 30 гаруй хувь нь тус бүсэд оршдог бөгөөд энэ нь хөдөө аж ахуйн чиглэлийн үйлдвэрлэл хөгжүүлэхэд түүхий эдийн нөөц байна гэдгийг харуулж байна.
- Хөдөлмөрийн насны хүн амын тоо жилээс жилд өсөж байгаа.
- Монгол улсын Засгийн газраас жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар бодлого баримталж хэрэгжүүлж байгаа.
- Тус бүсэд жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих олон улсын төсөл хөтөлбөрүүд үйл ажиллагаагаа явуулж, жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжилд дэмжлэг үзүүлж байна.
- Мэдээлэл, харилцаа холбооны салбарын хөгжил тус бүсэд сүүлийн жилүүдэд ахицтай байна.
- Бизнес эрхлэхэд татварын дарамт харьцангуй багассан

**Баруун бүсийн жижиг дунд үйлдвэрлэлийг явуулах болон хөгжүүлэхэд учрах саад бэрхшээл, сул тал**

Баруун бүсэд жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд дараах саад бэрхшээл, сул тал харагдаж байна.

- Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд хөрөнгийн эх үүсвэр дутмаг байна.
- Зээлийн барьцаа хөрөнгө зайлшгүй шаардлагатай. Бизнес эрхлэх бизнес санаа байдаг ч түүнийг хэрэгжүүлэхийн тулд зээл авах шаардлага гардаг ба анхлан жижиг бизнес эрхлэгчид дорвитой барьцаа хөрөнгө бага байдаг

- Зээл хугацаа богино, хүү өндөр байна. Бизнесээ эрхлээд үйл ажиллагаа нь тогтвортой явагдаж байхад зээлээ эргүүлж төлөх хугацаа болчихдог ба энэ нь цаашид үйл ажиллагаа явуулах эргэлтийн хөрөнгийг багасгадаг. Зээлийн хугацаа 3-6 гол төлөв байдаг
- Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд олон дүрэм журмын давхардал их байдаг.
- Бүсийн хөнгөлөлт байдаггүй. Энэ нь бүтээгдэхүүний өртгийг нэмэгдүүлэх сул талтай
- Төвийн зах зээлд нэвтрэхэд тээврийн зардал өндөр
- Баруун бүсийн 2 аймаг төвийн эрчим хүчинд холбогдоогүй, дийлэнх сум нь дизель станцтай нь үйлдвэрлэл хөгжүүлэхд томоохон бэрхшээл болдог
- Ажилгүйдлийн төвшин, өндөр Ажилгүйдлийн төвшин улсын дундаж 3.2 байхад баруун бүсэд 4.8 байгаа нь хүн амын худалдан авах чадвар бага, ядуурал их байгааг харуулж байна.
- Ядуурлын хамралтын хүрээ улсын дундаж 38.7 хувь, Улаанбаатар 20.4 байгаа бол баруун бүсэд 38.7 хувь байна.

**Баруун бүсийн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх арга зам**

Тухайн бүс нутагт том аж ахуй нэгж гэхээсээ илүү жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломжтой. Ялангуяа хүнсний болон өргөн хэрэглээний чиглэлийн үйлдвэрүүдийг сум, аймгийн төвүүдэд, экспортын баримжаатай үйлдвэрүүдийг бүсийн тулгуур төвүүдэд байгуулах боломжтой

Баруун бүсийн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхийн тулд дараах арга замаудыг дэс дараатай хэрэгжүүлэх боломжтой юм. Үүнд:

- Баруун бүс нутгийн үйлдвэрлэлийг дэмжих /бүсийн хөнгөлөлтийг бий болгох, урт хугацаатай, хүү багатай зээлд хамрагдах боломжийг бүрдүүлэх, дүрэм журмын давхардалыг багасгах гэх мэт / төслийг баруун бүсийн зөвлөл төр засагт уламжилж шийдвэрлүүлэх

- Эрчим хүчний олон эх үүсвэртэй болгох талаар санаачлагатай ажиллах
- Бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор бүсийн уулзалт семинарыг тогтмол зохион байгуулж туршлага солилцох, хамтарч ажиллах боломжийг бүрдүүлэх
- Баруун бүсийн брэнд бүтээгдэхүүнийг баруун бүсийн төдийгүй төвийн хэрэглэгчдэд сурталчлах ажлыг хамтарч зохион байгуулах
- Технологийн гадаад, дотоодын сургалтанд үйлдвэрлэлийн ажиллагсадыг хамруулахад байгууллага, эрх бүхий байгууллага, олон нийтийн байгууллага, орон нутгийн удирдлага нь хамтарч ажиллах
- Бүтээгдэхүүнээ борлуулахын тулд маркетингийн оновчтой, цэгцтэй бодлогыг бизнес эрхлэгчид явуулдаг байх

#### **Ашигласан ном зүй**

Монгол улсын “Засгийн газрын баруун бүсийн хөгжлийн хөтөлбөр” 2005, УБ

1. “Баруун бүсийн хөгжил” 2005 УБ
2. Г.Пүрэвдорж “Завхан аймаг” 2006 он
3. Увс аймгийн ЗДТГ “Увс- хөгжил” 2005 он
4. УСГ, Монгол улсын статистикийн эмхэтгэл 2000, 2006, УБ
5. “Завхан аймгийн нийгэм эдийн засгийн орчин”- ы судлагааны мэдээлэл 2007, Улиастай
6. Баруун бүсийн эдийн засгийн орчны судлагаа 2006, Улиастай
7. Өдөр тутмын сонин сэтгүүл 2003-2006 он